

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Монгол улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал, телемедицин МОН/007” төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/2/НА-СТА-ТХН

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p> | <p>Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас: 99240882 Цахим хаяг: Khosjargal.ts@audit.mn Ахлах аудитор/аудитор: М.Пагамдулам Утас: 261740 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn Гэрээгээр гүйцэтгэсэн: “Конфиденсе Аудит” ХХК-ийн Захирал: П.Ариунаа Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛС ДАХЬ ЗҮРХ СУДЛАЛ,
ЗҮРХНИЙ МЭС ЗАСАЛ, ТЕЛЕМЕДИЦИН
МОН/007 ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Ц.ТӨМӨР-ОЧИР ТАНАА

2024.02.29 № 07/581

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал, телемедицин МОН/007 төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улс дахь зүрх судлал, зүрхний мэс засал, телемедицин МОН/007 төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төсөл нь Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу 5 жилийн хугацаатай хэрэгжих ба санхүүжилтийг Монгол Улсын Засгийн газраас 2,960.0 мянган евро /мөнгөн бус/, Люксембургийн Засгийн газрын 5,000.0 мянган еврогийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөс бүрдүүлэхээр байна.

Аудитын гол асуудал

Люксембургийн хөгжлийн агентлагаас санхүүжүүлэх нийт 5,000.0 мянган еврогийн санхүүжилтийн 2,502.0 мянган евро нь мөнгөн бус хэлбэрээр оруулах гэрээтэй бөгөөд Люксембургийн талд гарсан зардлын тайланг авч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Төслийн төлөвлөгөөнд үндсэн 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 14.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichig\2024\0229 SNAG-35.Docx

0001051318

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-------------------------|-------------------------|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 3,593,805,090.00 | 2,499,546,974.87 |
| 31 | МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 3,593,805,090.00 | 2,365,548,616.70 |
| 31020104 | Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/ | - | 235,560,861.74 |
| 31020204 | Банканд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/ | 3,593,805,090.00 | 2,129,987,754.96 |
| 34 | Урьдчилгаа | - | 125,417,786.00 |
| 3406 | Урьдчилж төлсөн зардал | - | 107,900,000.00 |
| 3407 | Урьдчилгаа тооцоо | - | 17,517,786.00 |
| 340704 | Томилолтын урьдчилгаа | - | 17,517,786.00 |
| 35 | Бараа материал | - | 8,580,572.17 |
| 3504 | Хангамжийн материал | - | 8,580,572.17 |
| 350404 | Түлш, шатах тослох материал | - | 3,110,672.17 |
| 354700 | Бусад хангамжийн материал | - | 5,469,900.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | - | 339,322,893.32 |
| 39 | Үндсэн хөрөнгө | - | 339,322,893.32 |
| 3902 | Биет хөрөнгө | - | 319,061,868.32 |
| 390203 | Машин, тоног төхөөрөмж (компьютер) | - | 259,036,442.00 |
| 3902030 | Хуримтлагдсан элэгдэл | - | 10,429,120.54 |
| 390204 | Тавилга, аж ахуйн эд хогшил | - | 71,832,277.00 |
| 3902040 | Хуримтлагдсан элэгдэл | - | 1,377,730.14 |
| 3903 | Биет бус хөрөнгө | - | 20,261,025.00 |
| 390301 | Программ хангамж | - | 21,400,200.00 |
| 3930101 | Хуримтлагдсан элэгдэл | - | 1,139,175.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 3,593,805,090.00 | 2,838,869,868.19 |
| IV | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | - | - |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,593,805,090.00 | 2,838,869,868.19 |
| 5102 | Хуримтлагдсан үр дүн | - | 2,838,869,868.19 |
| 510201 | Өмнөх үеийн үр дүн | 3,593,805,090.00 | 3,593,805,090.00 |
| 510202 | Тайлант үеийн үр дүн | - | (754,935,221.81) |
| 52 | НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,593,805,090.00 | 2,838,869,868.19 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|---|-------------------------|-------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (i) | 3,578,818,740.00 | 1,984,321.17 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,578,818,740.00 | 1,984,321.17 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,578,818,740.00 | 1,984,321.17 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,578,818,740.00 | 1,984,321.17 |
| 1200043 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 3,578,818,740.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 1,984,321.17 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН (II) | - | 850,443,493.65 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 850,443,493.65 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 850,443,493.65 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 463,007,292.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 321,277,343.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 141,729,949.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | - | 374,490,175.97 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | - | 374,490,175.97 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 12,946,025.68 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | - | 12,946,025.68 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 3,578,818,740.00 | (848,459,172.48) |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 14,986,350.00 | 95,493,271.84 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 14,986,350.00 | 95,493,271.84 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 1,969,321.17 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 1,969,321.17 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 3,593,805,090,00 | (754,935,221.81) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-------------------------|---------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,578,818,740.00 | - |
| 12 | Татварын бус орлого | 3,578,818,740.00 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,578,818,740.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,578,818,740.00 | - |
| 1200043 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 3,578,818,740.00 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | - | 971,480,826.14 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 971,480,826.14 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 971,480,826.14 |
| 2101 | Томилолт, зочны зардал | - | 490,955,748.14 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 338,795,129.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 141,729,949.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 490,955,748.14 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 490,955,748.14 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,578,818,740.00 | (971,480,826.14) |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН | - | 352,268,919.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 352,268,919.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 352,268,919.00 |
| 222005 | Хөрөнгө | - | 232,332,998.00 |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 119,935,921.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (V)=(IV)-(V) | - | (352,268,919.00) |
| VI | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 14,986,350.00 | 95,493,271.84 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз | 14,986,350.00 | 95,493,271.84 |
| VII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 3,593,805,090.00 | (1,228,256,473.30) |
| VIII | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 3,593,805,090.00 |
| IX | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,593,805,090.00 | 2,365,548,616.70 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээн ий нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------|------------------------|-------------------------|--|
| 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 3,593,805,090.00 | 3,593,805,090.00 |
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | - | - | 3,593,805,090.00 | 3,593,805,090.00 |
| Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл | - | - | 3,593,805,090.00 | 3,593,805,090.00 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (754,935,221.81) | (754,935,221.81) |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | - | - | 2,838,869,868.19 | 2,838,869,868.19 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---------|---|-------------------------|-------------------------|-------------------------|-------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,965,843,000.00 | 1,323,749,745.14 | 2,642,093,254.86 | 33.4 |
| II | НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН | 3,965,843,000.00 | 1,323,749,745.14 | 2,642,093,254.86 | 33.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,112,343,000.00 | 1,091,416,747.14 | 20,926,252.86 | 98.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,112,343,000.00 | 1,091,416,747.14 | 20,926,252.86 | 98.1 |
| 2107 | Томилолт зочны зардал | 483,813,000.00 | 480,525,078.00 | 3,287,922.00 | 99.3 |
| 210701 | Гадаад албан томилолт | 342,013,000.00 | 338,795,129.00 | 3,217,871.00 | 99.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 141,800,000.00 | 141,729,949.00 | 70,051.00 | 100.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 628,530,000.00 | 610,891,669.14 | 17,638,330.86 | 97.2 |
| 210801 | Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 628,530,000.00 | 610,891,669.14 | 17,638,330.86 | 97.2 |
| 220 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ | 2,853,500,000.00 | 232,332,998.00 | 2,621,167,002.00 | 8.1 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 2,853,500,000.00 | 232,332,998.00 | 2,621,167,002.00 | 8.1 |
| 222001 | Техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж | 2,853,500,000.00 | 232,332,998.00 | 2,621,167,002.00 | 8.1 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | - | - | |
| 1200043 | Гадаад төслийн зээлээс санхүүжих | | - | - | - |
| | Төсвийн тохируулга | | 95,493,271.84 | - | - |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | | 3,593,805,090.00 | - | - |
| 3101 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | | 2,365,548,616.70 | - | - |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | | 8 | 8 | |
| 9001 | Удирдах ажилтан | | 1 | 1 | - |
| 9002 | Гүйцэтгэх ажилтан | | 7 | 7 | - |
| 9003 | Үйлчилгээний ажилтан | | - | - | - |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 281,132.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|-----|--------------|------------------|----------|------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Төслийн санхүүгийн тайланд 64 ш 352,268.9 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас Улсын 3 дугаар төв эмнэлгийн хэрэгцээнд төслийн санхүүжилтээр бэлтгэсэн 41 ширхэг 281,132,4 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж бүртгэлтэй байна. | 1 | 281,132.4 | | | 1 | 281,132.4 | | | 1 | 281,132.4 | 1 | 281,132.4 |
| Дүн | 1 | 281,132.4 | | | 1 | 281,132.4 | | | 1 | 281,132.4 | 1 | 281,132.4 |

Аудитаар илэрсэн 1 зөрчилд¹ албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|---|-----|--|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | |
| Төсвийн төлөвлөгөөг дээд шатны байгууллагаар батлуулахдаа, Люксембургийн хөгжлийн агентлагийн гэрээнд заасны дагуу 2023 онд нийт 632,000.00 евро зарцуулах эрхтэй буюу 2022 оны 12 сарын 31-ны албан ханшаар тооцож үзвэл 2,318,814.3 мянган төгрөгөөр төсөв батлагдахаар байхад 3,965,843.0 мянган төгрөгөөр батлуулсан нь, хэт хэлбэлзэлтэй байна. | 1 | | | | 1 | | | | | | | | |
| Дүн | 1 | | | | 1 | | | | | | | | |

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 107,834.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 107,834.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| <i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i> | | | | | | | | |
| Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 28 мэдээллээс 2 мэдээллийг мэдээлээгүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | 107,834.0 | | | 1 | 107,834.0 | | |
| Дүн | 1 | 107,834.0 | | | 1 | 107,834.0 | | |
| <i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i> | | | | | | | | |
| Тус төслийн нэгж нь улсын бүртгэлийн дугаар, татвар төлөгчийн дугаар зэргийг аваагүйгээс Улсын 3 дугаар төв эмнэлгийн регистр, татвар төлөгчийн дугаараар төлбөрийг гүйцэтгэж, цахим баримтууд, татварын болон нийгмийн даатгалын тайланг тайлагнасан. | 1 | | | | 1 | | | |
| Дүн | 1 | | | | 1 | | | |
| Нийт дүн | 2 | 107,834.0 | | | 2 | 107,834.0 | | |